

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

20.... оны .... сарын ....-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Зааварт өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”-ын 3.7 дахь хэсгийн 3.7.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/“3.7 дахь хэсэг:

3.7.2.Шалгалтад амжилттай хамрагдсан иргэн, ажилтанд иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын гэрчилгээг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн даргын гэрчилгээ олгох тухай тушаал гарсны дараа цахим хэлбэрээр олгоно.”.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга (цагдаагийн хурандаа П.Батбаатар)-д даалгасугай.

3.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД